



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/121

Эг

**Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй
зээл олгох тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 6.7, 6.8, 6.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хоршоог хөгжүүлэх сангийн зөвлөлөөр хэлэлцэн шалгаруулсан "Ану Эг ардын хоршоо"-ны "Кофе шоп ба зоогийн газар" төсөлд 50,000,000 (тавин сая) төгрөг, "Өлзий оршин дэвжих" хоршооны "Таван цулын борц" төсөлд 50,000,000 (тавин сая) төгрөгийн зээлийг тус тус олгосугай.

2. Тус сангаас зээл авч байгаа иргэдийн зээлийг зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэх, хүүгийн болон үндсэн төлөлтөө гэрээнд заасны дагуу төлж буй эсэхэд байнгын хяналт тавьж ажиллахыг хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн (Б.Энхболор), гэрээг үндэслэн санхүүжилтийг Хоршоо хөгжүүлэх сангаас олгохыг нягтлан бодогч (Н.Одончимэг) нарт даалгасугай.

3. Төслийн санхүүжилтээр олгогдсон зээлийн мөнгөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, эргэн төлөлтөө цаг хугацаанд нь санд төвлөрүүлэх, ажлын байр шинээр бий болгоход анхаарч, үр дүнтэй ажиллахыг төсөл хэрэгжүүлэх хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд анхааруулсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төсөл сонгон шалгаруулах хорооны дарга, Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Эрдэнэчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНСҮХ

232401341